



ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

**Улаанбаатар хот
2013 он**

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7, 48.10, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.6 дугаар зүйлийн 4, 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус удирдлага болгон Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.3, 48 дугаар зүйлийн 48.9.3, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.13 дугаар зүйлийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн “Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоолыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

Д.БАТСҮХ

ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл.Журмаар зохицуулах харилцаа

1.Монголын Хуульчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/-ны гишүүн хуульчдаас нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад баримтлах зарчим, үйл ажиллагааны төрөл, зохион байгуулах арга, хэлбэр, санхүүжилт, хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд хуульчдын оролцоог хангах, дэмжихтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа нь хуульчдын сайн дурын оролцоо, идэвх санаачлагад тулгуурлан нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг үнэ хөлсгүйгээр төлөөлөн хамгаалах зорилготой хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ, эрх зүйн иргэний боловсролыг дэмжих, хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой үйл ажиллагаанаас бүрдэнэ.

3.Энэхүү журмаар зохицуулагдаагүй бусад харилцааг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль¹, Монголын Хуульчдын холбооны дүрэм², Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмээр³ тус тус зохицуулна.

1.2 дугаар зүйл.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

1.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа нь дараах зарчимд үндэслэнэ:

- 1.1.хуульчдын сайн дурын оролцоонд тулгуурлах;
- 1.2.нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдэх;
- 1.3.хариу төлбөргүй байх;
- 1.4.хуульч нь нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг бусад ажил үүргээсээ ялгаварлалгүй байдлаар хэрэгжүүлэх;
- 1.5.мэргэжлийн нэр хүндээ эрхэмлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА, ХЭЛБЭР

2.1 дүгээр зүйл.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны төрөл

1.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа нь дор дурдсан төрөлтэй байна:

1.1.нийгмийн эмзэг хэсгийн иргэдэд Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үзүүлэх хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ;

¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

² Хуульчдын анхдугаар Их хурлын 2013 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан.

³ Хуульчдын анхдугаар Их хурлын 2013 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан.

1.2.хүмүүнлэгийн, соёл, боловсролын зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилгод нь хамаарах асуудлаар үзүүлэх хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ;

1.3.хүний эрхийг хамгаалах зорилготой үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, төрийн бус байгууллага, бүлгийн үйл ажиллагааны үндсэн зорилгод нь хамаарах асуудлаар үзүүлэх хууль зүйн үйлчилгээ;

1.4.хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрсөн хууль, нийтээр дагаж мөрдөх бусад хууль тогтоомжийг хүчингүй болгуулах асуудлаар эрх бүхий этгээдэд хандан шийдвэрлүүлэх үйл ажиллагаа явуулах.

[/Энэ заалтыг Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хурлын 6 дугаар тогтоолоор нэмсэн/](#)

2.Дор дурдсан үйл ажиллагааг хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд тооцож болно:

2.1.хуульчаас байгаль орчин, нүүдлийн уламжлалт мал аж ахуй, соёлын өв, нийтийн эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц, хэрэглэгчийн эрх зэрэг нийтийн эрх ашгийг хамгаалах болон тухайн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, төрийн бус байгууллага, бүлэгт үзүүлж буй хууль зүйн үйлчилгээ;

2.2.эрх зүйн иргэний боловсролыг дэмжих зорилгоор иргэд, олон нийтэд зориулан олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хууль тогтоомжийг сурталчлах, сургалт зохион байгуулах;

2.3.хуульч нь хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, түүнчлэн эрх зүйн шинэтгэл, хууль зүйн боловсрол, шинжлэх ухааны хөгжилд зориулж санхүүгийн болон эд материалын дэмжлэг үзүүлэх;

2.4.хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр хууль зүйн сургуулийн оюутнуудад зориулсан төрөл бүрийн арга хэмжээ, сургалт зохион байгуулах.

2.2 дугаар зүйл.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулах арга, хэлбэр

1.Холбооны Тамгын газар жил бүрийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр тодорхой ажлын төлөвлөгөө гарган, нийтийн тусын тулд болон төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр байгуулагдсан сайн дурын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

2.Хуульч бие даан, эсхүл Холбооны дэргэд байгуулагдсан сайн дурын хороо, өмгөөллийн хуулийн этгээд нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж болох бөгөөд энэ тухай ажлын тайлангаа Холбооны Тамгын газарт ирүүлж болно.

3.Хуульч нь нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан талаарх ажлын тайланг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор Холбооны Тамгын газар нэгтгэн гаргаж, нийтэд мэдээлнэ.

4.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан талаарх ажлын тайланг үзүүлсэн үйлчилгээний төрөл, хэлбэр, тухайн үйлчилгээнд зарцуулсан нийт болон үйлчилгээ бүрт зарцуулсан цаг, ажлын үр дүн гэсэн үзүүлэлтээр гаргана.

2.3 дугаар зүйл.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд хуульчдын оролцоог хангах

1.Шүүгч, прокурорын албан тушаалд ажиллаж байгаагаас бусад хуульч нь нэг жилд 40-өөс доошгүй бодит цагийг нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд зориулахыг эрмэлзэнэ.

2.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд зарцуулсан бодит цагт ирэх, очих замд зарцуулсан цаг, тухайн асуудлаар мэдлэгээ дээшлүүлэхэд зарцуулсан цаг хамаарахгүй.

3.Хуульч нь нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ өөрийн ажил, мэргэжлийн чиг үүрэгт харшлахгүй, үйлчлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй байдлаар зохион байгуулна. Хэрэв ийм тохиолдол үүснэ гэж үзвэл тухайн үйл ажиллагааг явуулахаас татгалзаж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ БОЛОН УРАМШУУЛАЛ

3.1 дүгээр зүйл.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны санхүүжилт

1.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг дор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

1.1.Холбооноос жил бүр төсөвлөсөн мөнгөн хөрөнгө;

1.2.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд зориулан иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, тусламж;

1.3.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр үйлчилгээ, туслалцаа авч буй этгээдээс тухайн үйл ажиллагаанд зориулан өгч буй зардал /улсын тэмдэгтийн хураамж, замын зардал, бичиг хэргийн зардал гэх мэт/;

1.4.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд хамаарах төслийг хэрэгжүүлэхэд зориулан Улсын төсвөөс олгосон санхүүжилт.

2.Энэ зүйлийн 1-д заасан санхүүжилтыг зөвхөн хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд зориулагдсан бичиг хэргийн зардал, хөдөө орон нутагт ажилласан томилолтын зардал, хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны талаарх сургалт, сурталчилгаа, ном товхимол хэвлэх, “Про-боно Хуульч” шагналын зардал зэрэгт зарцуулна.

3.2 дугаар зүйл.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах

1.Холбооны Тамгын газар жил бүр нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан хуульчид, тэдний явуулсан үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна.

2.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг бусдыгаа манлайлан өргөн хүрээнд, чанартай, үр дүнтэй хэрэгжүүлсэн хуульчийг жил бүр шалгаруулж, “Про-боно Хуульч” шагнал олгоно.

3.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд зарцуулсан 40 цагийг хуульчийн үргэлжилсэн сургалтын нэг багц цагт дүйцүүлэн тооцно.

4.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд зарцуулсан цагийг энэ зүйлийн 3-т зааснаар тооцохдоо нэг жилд нэгээс илүү багц цаг тооцохгүй.

5.Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд зарцуулсан цагийг хуульчийн үргэлжилсэн сургалтын багц цагт тооцож, бүртгэх асуудлыг Холбооны Сургалтын хороо шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

4.1 дүгээр зүйл.Журам хүчин төгөлдөр болох

1.Энэхүү журмыг 2014 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.